



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/282

Алтай хот

Хуулийн хэрэгжилтийг хангах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Цахим-Алтай" хөтөлбөртэй уялдуулан Улсын Их Хурлаас баталсан 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Алтанзагас	-(аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүн:	П.Хулан	-(аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Ц.Эрдэнэбат	-(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Х.Лхагважав	-(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
	О.Золжаргал	-(аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл, мэдээлэл технологийн бодлого хариуцсан мэргэжилтэн)
	У.Мягмарцэрэн	-(аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн төрийн үйлчилгээний операторч)

2.

-(Сумдын Засаг дарга нар)


-(Сумдын улсын бүртгэгч нар)

Нарийн бичгийн дарга: Г.Чүлтэмжамц-(Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

2.Цахим гарын үсгийн тухай хуулийг сурталчилах, хэрэгжилтийг хангах идэвхжүүлэлтийн ажлыг байгууллагын хүрээнд зохион байгуулахыг хэлтэс, агентлаг, албан байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал нарт, сумын хэмжээнд дэд ажлын хэсэг байгуулан ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Удирдамж боловсруулан батлуулж, хуулийг сурталчилан иргэдийг зөв ойлголт мэдээллээр ханган, цахим гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлж, үр дүнг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Алтанзагас)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

..... (MBCN)
..... (MBCN)
.....